МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/214 Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд
шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-нээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 2 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар батлсугай.

2. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 992 дахь хэсэг, 2008 оны 150 дугаар захирамжийн хавсралтын 16 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210577

*Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ны*
*өдрийн М/94 дугаар захирамжийн хавсралт*

| № | Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн | | | | Газар өмчлөх эрх шилжүүлсэн | | Газрын байршил | Газрын хэмжээ /м2/ | Газрын үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Овог нэр | Регистр | | | |
| 1 | Боржгин | Элбэгсүрэн | Отгонбаяр | ЗК73122811 | Б.Оюунтуяа | ЗК76092903 | Зоог 11-1110 | 1289 | 2578000 |
| | | | | | О.Хүүхайчин | ЗК98011417 | | | |
| | | | | | О.Рэнцэндорж | ЗК02222713 | | | |
| 2 | Лимбэт | Дашгончиг | Гансүрэн | ЗЮ75122262 | Ё.Батхүү | ЗЮ77062477 | Боржигон 29-2902 | 1200 | 2400000 |
| | | | | | Б.Анхбаяр | ЗЮ98042909 | | | |
| | | | | | Б.Энхбаяр | ЗК07281619 | | | |